



**“ТӨВ ЦЭНГЭЛДЭХ ХҮРЭЭЛЭН” ХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн
бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 25/46 дугаартай тогтоол, 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн бүтэц, орон тоог нэгдүгээр хавсралтаар, Цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн бүтэц, орон тоо, цалингийн хэмжээнд багтаан үйл ажиллагаа явуулахыг Гүйцэтгэх захирал (Д.Лхагвадулам)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга (Ч.Дашдэмбэрэл)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ИХБАЯР

0017350103

“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025
оны 10 дугаар сарын 17 өдрийн
дугаар тогтоолын хавсралт /



Д.Д	Албан тушаал	Орон тоо
Захиргааны хэлтэс		
1	Гүйцэтгэх захирал	1
2	Үйл ажиллагаа хариуцсан захирал	1
3	Хүний нөөцийн менежер	1
4	Хуулийн мэргэжилтэн	1
5	Нарийн бичиг, захирлын туслах	1
6	Архив, бичиг хэргийн ажилтан	1
7	Тайлан төлөвлөгөө, биелэлт, гэрээ хариуцсан ажилтан	1
Санхүүгийн хэлтэс		
8	Ерөнхий нягтлан бодогч	1
9	Худалдан авалт, тендер хариуцсан мэргэжилтэн	1
10	Тооцооны нягтлан бодогч	1
11	Нярав	1
Маркетинг, борлуулалтын хэлтэс		
12	Маркетинг борлуулалт хариуцсан захирал	1
13	Борлуулалтын менежер	2
14	Төслийн менежер	1
15	Орлого бүрдүүлэлтийн мэргэжилтэн	1
16	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтэн	1
17	График дизайнер	1
18	Төслийн санхүүгийн мэргэжилтэн	1
19	Төслийн ажилтан	1
Аж ахуйн алба		
20	Аж ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн	1
21	Техник хариуцсан инженер	2
22	Инженер техникийн туслах ажилтан	1
23	Камер хянагч	1
24	Цахилгаанчин	1
25	Сантехникч	1
26	Аж ахуйн ажилтан /мужаан/	1
27	Аж ахуйн ажилтан /туслах/	1
28	Жолооч	1
29	Төлбөртэй зогсоолын ажилтан	6
30	Цэвэрлэгээ үйлчилгээний ажилтан	5
31	Харуул хамгаалалтын гэрээт ажилтан	3
НИЙТ		44